НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 12 дугаар сарын 16 Дугаар 57 Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 2022 оны газар зохион
байгуулалтын төлөвлөгөөний биелэлт дүгнэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 заалт, дүүргийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/995 тоот албан бичгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг Хангалттай гэж дүгнэж хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны … дугаар сарын …-ны өдрийн есдүгээр хуралдааны ..... дугаар тогтоолын хавсралт

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 2022 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДЭХ АЖЛУУД

№	Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4
		1.1. Хууль эрх зүйн чиглэлээр хийх ажлууд	
1	Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Газрын төлбөрийн хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай хууль, Кадастрын тухай хууль зэрэг 5 хуульд өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох талаар газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон дээд байгууллагатай нягт хамтран ажиллаж, зарим эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар санал өгч оролцоно.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанаар Газрын тухай багц хуулийн төслийг хэлэлцүүлж Улсын Их Хуралд мэдүүлэхээр шийдвэрлэлээ. Газрын багц хуульд Газрын ерөнхий хууль, Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Кадастрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулиуд багтаж байна. Газрын багц хууль батлагдсанаар Монгол Улсыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан шинээр олгох газрыг төлөвлөх, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн бүх шатны баримт бичигт салбарын яам, агентлаг болон иргэд, олон нийтээс санал авах, газрын нэгдсэн төлөвлөлт, бүртгэлээр дамжуулж салбар хоорондын уялдааг хангах, төрөөс олгосон газар өмчлөх эрх болон газрын хязгаарлагдмал эрхтэй иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрхийг хамгаалж, газар олгох, бүртгэх, гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахим системээр ил тод, түргэн шуурхай байгуулах, иргэн, хуулийн этгээд газрын цахим биржээр дамжуулан газар авах, арилжаалах болон Монгол Улсын иргэн өмчилж авсан газраа Монгол Улсын хуулийн этгээдэд газрын хязгаарлагдмал эрхээр шилжүүлэх, худалдаа үйлчилгээний зориулалтаар ашиглах, төрийн өмчийн газрыг Иргэний хуулийн суурь эрхийн зохицуулалттай нийцүүлэх, иргэн хуулийн этгээдэд тодорхой зориулалт, хугацаагаар шилжүүлэх, гэрээгээр ашиглуулах боломж бүрдэж, нийтийн зориулалттай орон сууц болон олон өмчлөгчтэй барилгын доорх газрын эрхийг өмчлөгч нарт нь дундын мэдлийн газрын эрхийг олгох боломж бүрдэх юм. Албаны даргын 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/132 дугаар тушаалаар Газрын багц хуулийн төсөлд тусгах санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь 2022 оны 10 дугаар сарын 21, 28-ний өдрүүдэд хуралдаж, Газрын багц хуульд багтсан Газрын ерөнхий хууль, Монгол Улсын Иргэнд	100

		газар өмчлүүлэх тухай хууль, Кадастрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулиудад тус тус тусгах саналаа боловсруулж, эрх бүхий байгууллагад уламжлаад байна.	
2	ДИТХ, Засаг даргаас гарах газар холбоотой тогтоол шийдвэрүүдэд санал өгч газрын тухай хуулинд нийцүүлэх талаар хамтран ажиллана. Дүүргийн 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай судалгаа, шинжилгээг хийж дүүргийн удирдлагуудыг мэргэжлийн мэдээллээр ханган төслийг танилцуулах, батлуулах	Газрын багц хуульд багтсан Газрын ерөнхий хууль, Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Кадастрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулиудад тус тус тусгах саналаа боловсруулж, эрх бүхий байгууллагад уламжлаад байна. Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны А/722 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан тус дүүргийн 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналуудыг нэгтгэн боловсруулж дүүргийн удирдлагуудыг мэргэжлийн мэдээллээр ханган төслийг танилцуулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар ажиллаж байна.	100
3	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолын холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах, шинэчлэх талаар санал өгч оролцоно.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Менежмент төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн шейф файл дээр суурин судалгаа хийж, дүүргийн нутаг дэвсгэрийн усны эх үүсвэр, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд (ундны усны 50м онцгой хамгаалалт)740, хориглолтын бүсэд 349 иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.	100
4	Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын дагуу газрын үнэлгээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг шинэчлэх, дүгнэх, хэрэгжилтийг зохион байгуулах	Газрын кадастрын мэдээллийн системд суурилсан Газрын төлбөр, татварын системд Газрын татвар, төлбөрийг газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжийг ашиглан бүрэн ногдуулж, тайлагнах ажлын хүрээнд Газрын төлбөр, татварын системд 2022 онд ногдуулалт үүссэн хүчинтэй гэрээний тоо нийт 29,995 байна. Үүнээс нэхэмжлэх үүссэн гэрээний тоо 28,925 буюу 96.4 %-ийн биелэлттэй байна. E-gazar, E-Mongolia, E-Barimt зэрэг аппликейшнүүдийг ашиглан газрын төлбөрөө хэрхэн төлөх gazar.ub.gov.mn болон egazar.gov.mn сайтуудыг ашиглан газартай холбоотой бүх төрлийн мэдээллийг авах талаар зөвлөгөө өгч цахим үйлчилгээг ажилдаа нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн газрын төлбөрийн ногдуулалт, төлөлттэй холбоотой дундын вэб мэдээллийн санд иргэн хуулийн этгээдийн баяжилт хийв. Газрын кадастрын мэдээллийн санд суурилан газрын төлбөр төлөх үйл явцыг хөнгөвчилж, зохих хууль тогтоомжийн дагуу газрын төлбөрийг үнэн зөв ногдуулж татварын албанд илгээж байна.	96.4
5	Тусгай хамгаалалттай газар нутаг (Богдхан уул), түүний орчны бүсийн хилийн зааг, менежментийн эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх асуудлын хүрээнд холбогдох төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах, санал хүргүүлэх	Улсын тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Газар зохион байгуулалт хийх журмын 6.1-д Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох; 6.2-д Улсын тусгай хэрэгцээний газрын хил, заагийг тогтоох, өөрчлөлт оруулах, тодотгох зорилгоор газар зохион байгуулалт хийхээр төлөвлөж байна. УИХ-н 1995 дугаар 26 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Богдхан уулын дархан заацат газрын хилйн заагийг шинэчлэн батлахтай холбогдуулан шаардлагатай баримт, мэдээллийг цуглуулж үндэслэл бүхий танилцуулга бэлтгэж дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр санал оруулсан. Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, “Богдхан уул”-ын Дархан цаазат газрын хилийн цэсийг нарийвчлан тогтоосон 41423 га газраас суурьшил үүсэж, барилгажилт, газар олголт явагдсан **92.8 га** газрыг хязгаарлалтын бүсээс гаргах санал гаргаж, суурьшил	100

		үүсээгүй, газар олголт хийгдээгүй 1 байршил дээр талбайн хэмжээг нэмэгдүүлэн 41423 га газрыг хэвээр үлдээхээр санал оруулсан.	
6	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг Улаанбаатар хотын эдэлбэр газар, түүнтэй холбоотой дүрэм, журмын төсөл шинэчлэн боловсруулалтад санал өгч оролцох	Нийслэл хотын нийтийн эдэлбэрийн газрын хэмжээг тогтоох, ашиглалтын журмын төсөлд, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/113 дугаар захирамжаар Нийслэлийн тэг гортиг бүхий эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлт, эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийн төсөлд санал өгч ажилласан.	100
1.2 Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил			
7	Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг хангах	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/126 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавьж ажилласан бөгөөд төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хангах, захиалагчийн хяналт тавих, хамтарч ажиллах чиглэлээр 6 удаагийн ажлын хэсэг байгуулан, үр дүнтэй ажилласан. Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах үүднээс төслийг эрдэмтэн, судлаачдын багаар хэлэлцүүлж, саналуудыг тусган ажилласан бөгөөд 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал, 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөчдийн Зөвлөлийн хуралдаан, 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын VII дугаар хуралдаан, 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын VIII дугаар хуралдаанаар тус тус хэлэлцүүлэн дэмжигдэж батлагдсан.	100
8	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, холбогдох шийдвэрийг гаргуулан бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулж ажиллах	Ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсэд орсон нэгж талбартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй иргэн, хуулийн этгээдийн нэгж талбарын судалгааг нарийвчлан гаргасан. Үүнд: Ойн хамгаалалт бүс буюу тэлэн ургах бүсэд-4654, Ойн бүсэд- 1622 нэгж талбар орж нийт 113,54 га хамарч байгаа бөгөөд газар дээрэ 103 нэгж талбар нь объеокттой, 1519 нэгж талбар нь хоосон байгаа судалгаа гаргасан. Газар эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдэд олгосон зөрчлийг арилгахаар 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 болон Ойн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн цахим сайтаар газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай албан мэдэгдэл хүргүүлсэн. Тус дүүргийн Засаг даргын 2022 оны А/422 дугаар захирамжаар 86 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг хүчингүй болгосон.	100
9	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг ил тод болгох, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Газрын бирж”-ийн цахим систем (www.mle.mn)-ийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийн санг Газрын биржийн цахим систем, Газрын кадастрын мэдээллийн санд суурилан цуглуулах ажлыг зохион байгуулах, олон нийтэд ил тод болгох ажлын хүрээнд Газрын биржийн цахим системийн мэдээллийн бааз бэлтгэх зорилгоор зах зээлийн үнийн мэдээллийг 2022 онд **MLE.MN** системд 457 газар эзэмшигч, ашиглагч нарын мэдээллийг бүртгэн оруулав.	100

10	Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулахтай холбогдуулан бэлтгэл ажлыг зохион байгуулах	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Ай Си Ти групп” ХК-тай 2022 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн Улсын хаягийн нэгдсэн системд бүрэн холбох НХААГ/202212155 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажиллаж байна. Ажил гүйцэтгэх хуваарийн дагуу 5 дугаар сарын 23-ны өдөр гүйцэтгэгч байгууллагатай уулзаж, мэдээлэл солилцсон. Гэрээний дагуу гүйцэтгэгч байгууллагаас 8 дугаар сарын 24-ий өдрийн 22/624 дугаартай албан бичгээр эхлэлийн тайланг ирүүлснийг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар хурлаар хэлэлцүүлж, ХБМХ-2022/20 дугаар акт үйлдэн хүлээн авсан. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” 180 дугаар тогтоол, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журамд өөрчлөлт оруулах тухай” 181 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл ирүүлсний дагуу нийт албан хаагчдад сургалт зохион байгуулснаар хаягжуулалтын нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангагдаад байна.	100
11	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, системийн хөгжүүлэлтэд санал өгч хамтран ажиллах	“Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем” нь газрын харилцааны цогц үйл ажиллагааг салбар бүрийн оролцоог ханган нэгдсэн стандарт, арга зүйгээр эрхлэх үндсэн чиг үүрэг бүхий байрлалд суурилсан, нэгдсэн стандарт бүхий өгөгдөл, дүн шинжилгээ хийх, боловсруулах цахим систем, өгөгдөл, мэдээллийг хадгалах, түгээх зориулалт бүхий техник хангамж, мэдээллийг түргэн, шуурхай, найдвартай солилцох өндөр хурдны дэд бүтэц зэргээс бүрдсэн нэгдсэн цахим систем юм. Уг нэгдсэн цахим систем нь: - Төлөвлөлтийн; - Газрын биржийн; - Үнэлгээ, татвар, төлбөрийн; - Кадастрын; - Мониторингийн; - Хот байгуулалтын гэсэн өгөгдөл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээлэл түгээх зэрэг боломжуудыг багтаасан үндсэн цогц 6 цахим систем болон эдгээрт дэмжлэг үзүүлэх Геодезийн, Хаягийн, Суурь судалгааны гэсэн 3 мэдээллийн сангаас бүрдэнэ. Дээрх 6 цахим системийг холбогдох журмын дагуу хэрэглээнд нэвтрүүлэн, байгууллагын өдөр дутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.	100
1.3 Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил			
12	Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын зөрчлийг арилгаж, газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Газрын төлбөрийн үлдэгдэлтэй нийт 1505 иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган 7 удаагийн масс мессеж хүргүүлж, Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй хамтран 1 сарын хугацаатай газрын төлбөр төлөлтийг эрчимжүүлэх удирдамж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Баянзүрх дүүргийн татварын хэлтэстэй хамтран “Газрын төлбөрийн 2022 оны төсөв бүрдүүлэх аян”-ны хүрээнд:	100

		• Газрын төлбөрийн үлдэгдэлтэй 538 иргэн, хуулийн этгээдийн судалгааг нэгтгэн гаргаж газар дээр нь очиж ажилласан. • Газрын төлбөр, татварын системд 2022 онд ногдуулалт үүссэн хүчинтэй 29,995 гэрээ байна. Үүнээс нэхэмжлэх үүссэн гэрээний тоо 28,925 буюу 96.4 %-ийн биелэлттэй байна. • Газар эзэмшиж, ашиглаж байгаа хуулийн этгээдийн санхүү хариуцсан ажилтан, алба хаагчдад 3 удаагийн сургалт зохион байгуулсан. • Нийтийн эзэмшлийн зам, талбайд үйл ажиллагаа явуулж буй 200 гаруй түр байгууламж /өргөтгөл /-ийн суурин судалгааг боловсруулж, .shp файлтай холбохоор хээрийн судалгаа хийж, газрын төлбөр төлөх мэдэгдэл өгсөн. • Газрын төлбөр, татвар, egazar аппликейшн, egazar.gov.mn цахим хуудасыг сурталчилсан 1 шторк бэлдэж, цахим орчинд түгээсэн. • Газрын төлбөрийн үлдэгдэлтэй иргэн, хуулийн этгээдэд үүрэн холбооны операторуудаар 6 удаагийн давтамжаар 3906 иргэнд масс мессэж илгээсэн. • Хөрөнгийн бүртгэл үүсээгүй 4166 гэрээг газрын төлбөр, татварын системд илгээж, бүртгэв.	
13	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 24/17 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах, буулгах журмын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчил болох Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Автай сайн хотхоны" урд байрлах олон жил болсон барилгын цамхагт краныг нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1011 дүгээр захирамжийн дагуу албадан буулгаж, газар чөлөөлсөн. Тус дүүргийн нутаг дэвсгэрт орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн орц, гарц хаасан нийт 75 байршилд газрын зөрчлийн судалгааг гаргасан. Дүүргийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгаж орц, гарц, чөлөөлөх тухай” А/149 дүгээр захирамжийг үндэслэн нийт 23 байршлаас 23 байршлын зөрчлийг арилгасан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/585 дугаар захирамжийн хүрээнд нутаг дэвсгэрт нийт 52 байршилд газар чөлөөлөлт хийхээр төлөвлөснөөс 49 байршилд газар чөлөөлөлтийн ажлыг хийж гүйцэтгэж, зөрчлийг арилгасан.	98.1
14	Орон сууцны хороолол дундах автомашины гараашуудыг буулган газрыг чөлөөлж, чөлөөлөгдсөн газарт олон нийтэд зориулсан ногоон байгууламж, тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийх боломжийг бүрдүүлэн нийтийн эдэлбэр газраар бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах	Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388, “Газар албадан чөлөөлөх тухай” А/1259, дүүргийн Засаг даргын “Газар албадан чөлөөлөх тухай” А/61 дүгээр захирамжийг үндэслэн 45 байршлын 1284 гарааш буулгасан. Газар чөлөөлсөн талбайд тохижилтын ажил хийхээр дүүргийн Тохижилт үйлчилгээний хэлтэс нь бэлтгэл ажлаа хангаад, тохижилт хийж байна. Үүнд: Тус дүүргийн 1 дүгээр хороо, 22 дугаар байрны баруун талд 40 гарааш буулгасан талбайд ногоон байгууламж, явган зам, машины зогсоол, 6 дугаар хороо 22а байрны баруун талд 15 гарааш буулгасан талбайд ногоон байгууламж, явган зам, машины зогсоол, 18 дугаар байрны зүүн талд 10 гарааш буулгасан талбайп ногоон байгууламж, явган зам, машины зогсоол, 18 дугаар хороо 111-р сургуулийн зүүн хойд талд 62 гарааш буулгасан талбайд ногоон байгууламж, явган зам, машины зогсоол, 5 дугаар хороо 8, 9, 10 дугаар байрны зүүн талд 3*3 сагсан бөмбөгийн талбай, хүүхдийн тогтлоомын талбай, 4 дүгээр хороо, 14 дүгээр сургуулийн хойд талд авто машины	100

		зогсоол, 7 дугаар хороо 97 дугаар сургуулийн баруун талд тохижилт, авто машины зогсоол зэрэг иргэдийн аюулгүй байдлыг хангасан тус тус тохижилт хийгдсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Нийтийн эдэлбэр газрын байршил, хэмжээг тогтоох тухай” 54, 98 дугаар тогтоолоор гарааш чөлөөлсөн 10 байршлийг нийтийн эдэлбэрт газарт бүртгэж баталгаажуулсан.	
15	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд барилгын норм дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон шийдвэрийг нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжаар цуцлах, тухайн байршилд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд уялдуулан тохижилт, ногоон байгууламж, биеийн тамирын талбайг байгуулах ажлыг зохион байгуулах	Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388, “Газар албадан чөлөөлөх тухай” А/1259, дүүргийн Засаг даргын “Газар албадан чөлөөлөх тухай” А/61 дүгээр захирамжийг үндэслэн **45 байршлын 1284** гарааш буулгасан. Гарааш чөлөөлсөн 1 байршилд 3*3 сагсан бөмбөгийн талбай, 9 байршилд тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбай, авто машины зогсоол хийгдээд байна.	100
16	Налайх дүүрэг, Баянзүрх дүүргийн хилийн цэсийн маргааныг холбогдох дээд шатны байгууллагуудаар шийдвэрлүүлэх, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах	Хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх ажлын хэсгийн хурлаар 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхор нуурын нутагт 45 нэгж талбар, 20 дугаар хороо Энгэр шанд, Майхан уул, Их амуудад нийт 292 нэгж талбарыг тусган газар эзэмших эрх олгож шийдвэрлэх хурлын шийдвэр гарсан.	100
17	Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутаг түүний хамгаалалтын бүсийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэх, хяналт тавих	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Нийтийн эдэлбэр газрын байршил, хэмжээг тогтоох тухай” 54, 98 дугаар тогтоолоор гарааш чөлөөлсөн 10 байршлийг нийтийн эдэлбэрт газарт бүртгэж баталгаажуулсан. Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо, Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын бүсийн хил заагийг шинэчлэн тогтоох тухай санал ДИТХ-аар хэлэлцүүлэхээр саналаа хүргүүлсэн. Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо “Баянзүрх хайрхан” хамгаалалтын бүсийн хил заагийг шинэчлэн тогтоох тухай саналаа нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.	100
18	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь хүчингүй болж, төрийн мэдэлд шилжсэн газруудыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн нээлттэй дуудлага худалдааны зарчмаар газар эзэмших, ашиглах эрх олгох ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах	Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нь хүчингүй болж, төрийн мэдэлд шилжсэн Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны 1, 20 дугаар хорооны 3 байршилд тус тус газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн цахим дуудлага худалдааг зохион байгуулсан. Дуудлага худалдааны ялагчид Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/901 дүгээр захирамжаар газар эзэмших эрх олгосон байна.	100
19	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх Шархад дэд төвүүдийн газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	Шар хад дэд төвийн хүрээнд хийгдэх цэцэрлэг, олон нийтийн хөгжлийн төв, бизнес инкубатор төв, өрхийн эрүүл мэндийн төв, үерийн далан, авто зам болон инженерийн байгууламжийн нөлөөлөлд 423 нэгж талбар урьдчиласан байдлаар өртссөн бөгөөд тус нэгж талбаруудыг чөлөөлөхөд 19,6 тэрбум төгрөгийн төсөөллийн үнэлгээ гараад байна. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн А/352 дугаар захирамжаар 1 нэгж талбарт 114,893,531 төгрөгийн нөхөх олговрыг олгож, газрыг чөлөөлсөн. Зураг төсөл эцэслэн батлагдаагүй байна.	100

20	Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан газар нутгийн судалгааг гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал бэлтгэн, холбогдох шийдвэрийг гаргуулах	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны эрхтэй мэргэжлийн байгууллагуудаас 2022 онд нийтдээ 4433 тайланг ирүүлсэн бөгөөд хянаж баталгаажуулсан 4347, судлагдаж байгаа 86 тайлан байна. Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 10-ны өдрийн хооронд тус албанд хамаарах Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Улиастайн ам болон Баяндөхөмийн Гүнжийн хоолойд байрлах 2 цэгийн байршилд хээрийн судалгаа хийж холбогдох тайланг 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 16/414 тоот албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлэн ажилласан. Нийслэлийн хот тосгон бусад суурин газрын мониторингийн 300 цэгт хөрсний эрүүл ахуй, хүнд металлын бохирдлын судалгаа хийх, бохирдолд өртсөн газруудын байршлыг тодорхойлох, хөрс хамгаалах, бохирдлыг бууруулах чиглэлээр батлагдсан удирдамжийн дагуу тус албанд хамаарах 37 цэгийн хээрийн судалгааг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлж хийсэн боловч хөрсний дээжийг шинжлэн дүгнэлт гаргах лаборатори сонгогдоогүй, ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдаагүй шалтгааны улмаас тухайн ажил хойшлогдсон. Энэ талаар нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр чиглэл авахаар 16/380 албан тоот хүргүүлсэн. 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас хөрсний лаборатори сонгогдсон тул хөрсний дээж авах талаар чиглэл ирсэний дагуу 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 36 цэгийн дээжийг хөрс судлалын “Дээж” лабораторид хүлээлгэн өгсөн. Хөрсний дээжийн дүгнэлтийг хүлээж байна.	100
21	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах	2022 онд Газрын мониторингийн цахим системд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааг баталгаажуулахаар ирүүлсэн тайлан, дүгнэлтийг судалж, 4347 нэгж талбарын тайланг баталгаажуулсан. Мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусан эсэх болон тайланг үнэн бодитой тайлагнаж байгаа тал дээр мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.	100
22	Иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрөлгүйгээр ашиглаж буй илүү талбайн нь бусдын газар эзэмшилтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихөөргүй, нийслэлийн газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үе шатны төсөл, газар ашиглалтын бүсчлэлтэй уялдаж байгаа тохиолдолд ашиглаж буй илүү талбайн хэмжээг нэмж эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар шийдвэрлэх, болон газрын давхардлыг арилгах ажлыг зохион байгуулах.	Тус дүүргийн нутаг дэвсгэрт “Газрын эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөлийн хурал”-аар 5 удаагийн захирамжаар 7 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг шийдвэрлэсэн байна. газар ашиглалтын бүсчлэлтэй уялдаж байгаа тохиолдолд ашиглаж буй илүү талбайн хэмжээг нэмж эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг дуудлага худалдааны зарчмаар шийдвэрлэх, болон газрын давхардлыг арилгах ажлыг зохион байгуулах. Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын зөрчлийг арилгаж, газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 5 удаагийн талбай хэмжээ өөрчлөх 5 удаагийн захирамжаар 6 иргэн хуулийн этгээдээс газрын дуудлага худалдааны анхны үнийг нийслэлийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлэн ажиллаад байна.	100

23	Хувийн хэвшлийн эзэмшилд байгаа газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болох нөхцөл бүрдсэн газруудад холбогдох арга хэмжээ авч, газрыг дахин зохион байгуулалтад оруулах асуудлыг шийдвэрлэх.	Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2 жил буюу түүнээс дээш жил ашиглаагүй газарт хэзрийн судалгаа хийж, 55 иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган нийслэлийн газар зохион байгуулалтын албаны кадастрын хэлтэст хүргүүлсэн бөгөөд үүнээс 28 иргэн хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох захирамжийн төсөл бэлтгэн ажиллаж байна.	100
24	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, объектуудыг буулгах, нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчил болох Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Автай сайн хотхоны" урд байрлах олон жил болсон барилгын цамхагт краныг нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1011 дүгээр захирамжийн дагуу албадан буулгаж, газар чөлөөлсөн. Тус дүүргийн нутаг дэвсгэрт орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн орц, гарц хаасан нийт 75 байршилд газрын зөрчлийн судалгааг гаргасан. Дүүргийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгаж орц, гарц, чөлөөлөх тухай” А/149 дүгээр захирамжийг үндэслэн нийт 23 байршлаас 23 байршлын зөрчлийг арилгасан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/585 дугаар захирамжийн хүрээнд нутаг дэвсгэрт нийт 52 байршилд газар чөлөөлөлт хийхээр төлөвлөснөөс 49 байршилд газар чөлөөлөлтийн ажлыг хийж гүйцэтгэж, зөрчлийг арилгасан. Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт шинээр тавигдах авто замын трассын нөлөөлөлд 259 нэгж талбар өртсөнөөс 157-н нэгж талбар нь өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайгаас сунгаж хашаа барьсан байсныг “Газрын тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4 дэх хэсгүүдийг үндэслэн хугацаатай мэдэгдэл өгч хашааг татуулсан. Трассын нөлөөлөлд өртсөн 86 иргэний газар болон эд хөрөнгөд үнэлгээ хийлгэн, газрыг нөхөн олговортойгоор чөлөөлж, замын ажил саадгүй хэрэгжих нөхцөл боломжоор хангасан. Тухай авто замуудын трассын нөлөөлөлд өрсөн 25 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 700 м2 газрын тус тус олгосон.	94.7
1.4 Газар өмчлөлийн чиглэлээр хийх ажлууд			
25	Хуучин суурьшил бүхий газарт олон жил амьдарсан, газраа эзэмшиж, өмчилж аваагүй иргэдэд Газрын тухай хууль, МУ-ын иргэнд Газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу холбогдох материалыг бүрдүүлж гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах.	Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 121 дүгээр тогтоол, НИТХ-ын 2021 оны 12 сарын 03-ны өдрийн 11/33 дугаар тогтоолын хэрэгжилт нийслэлийн Засаг даргын 2022-04-20-А/540 дүгээр захирамжаар **17** иргэн, 2022-05-26-А/730 дугаар захирамжаар **85** иргэн, 2022-06-02-А/754 дүгээр захирамжаар **40** иргэн, 2022-06-22-А/841 дүгээр захирамжаар **108** иргэн, 2022-07-21-А/982 дүгээр захирамжаар **68** иргэн, 2022-07-25-А/992 дүгээр захирамжаар **93** иргэн, 2022-08-19-А/1074 дүгээр захирамжаар **55,** 2022 оны 09 сарын 28-ны өдрийн А/1251 дүгээр захирамжаар **64** иргэн**,** 2022 оны 09 сарын 28-ны өдрийн А/1253 дугаар захирамжаар **50** иргэн**,** 2022 оны 10 сарын 06-ны өдрийн А/1288 дугаар захирамжаар **33** иргэн, 2022 оны 11 сарын 04-ний өдрийн А/1105 дугаар захирамжаар **39** иргэн, 2022 оны 11 сарын 14-ний өдрийн А/1446 дугаар захирамжаар **66** иргэн, 2 удаагын хурлын төслөөр **122** иргэн, нийт **839** иргэний эзэмшил газрыг өмчлөж шийдвэрлэсэн байна. **71%**	71

26	Баянзүрх дүүргийн ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах	Тус дүүргийн 20 дугаар хороонд Дээндий аманд 4.2га, Их хуандайн аманд 2.95, Арцатын аманд 3.98, 11 дүгээр хороо Хонхорт 10.5га нийт 4 байршилд 21.63га газрын саналыг гарган 2022 оны 11 сарын 18-ны өдрийн 15/1907 албан тоотоор Газар өмчлөлийн хэлтэст хүргүүлсэн.	100
27	Газар өмчлөх иргэдийн санал, хүсэлтийг цахим системээр хүлээн авах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх	Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны цахим үйлчилгээг хороодоос үзүүлэх тухай” А/84 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах, цахим систем Egazar.gov.mn-ийг сурталчлах, газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх, 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгах өмчлөлтэй холбоотой саналыг хороодоос хүлээн авах ажлын талаарх сургалт, мэдээлэл, арга зүйгээр хангаж байна. Тус сургалтанд 35 хороодын 79 хэсгийн ахлагч, зохион байгулагч, хороодын засаг дарга нар хамрагдсан байна.	100
1.5 Газрын кадастрын чиглэлээр хийх ажлууд			
28	Дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, олон нийтийн барилга байгууламж орчмын нийтийн эзэмшлийн зам талбай, машины зогсоол, явган хүний зам, цэцэрлэгжилтийн талбай, авто болон явган зорчигчийн орц гарц, СӨХ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эдэлбэр газар, авто замын улаан шугам, инженерийн байгууламж, шугам сүлжээ, ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгосон дүүргийн Засаг даргын захирамжийг судалж, холбогдох арга хэмжээг үе шаттай авах.	**Усан сан:** Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Менежмент төлөвлөлтийн хэлтсээс ирүүлсэн шейф файл дээр суурин судалгаа хийж, дүүргийн нутаг дэвсгэрийн усны эх үүсвэр, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсэд /ундны усны 50м онцгой хамгаалалт/ 740, хориглолтын бүсэд 380 иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. **Үер, халиа**: Нийслэлийн Баянзүрх дүүргийн онцгой комиссын даргын 2022 оны “Шар усны үер болон хөрсний усны халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгавар, дүүргийн Засаг даргын 2022 оны “Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” А/72 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 5, 9, 10, 17, 21, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт үер халиа дошин үүсч болзошгүй нэгж талбаруудын судалгааг гаргасан. Эрсдэлтэй 92 нэгж талбарын айлуудад газар чөлөөлөх шаардах хуудас хүргүүлэн ажиллаж байна. **Ойн бүс:** Ойн сан бүхий газрын хамгаалалтын бүсэд орсон нэгж талбартай газар эзэмших эрхийн гэрчилгээтэй иргэн, хуулийн этгээдийн нэгж талбарын судалгааг нарийвчлан гаргасан. Үүнд: Ойн хамгаалалт бүс буюу тэлэн ургах бүсэд-4654, Ойн бүсэд- 1622 нэгж талбар орж нийт 113,54 га хамарч байгаа бөгөөд газар дээрэ 103 нэгж талбар нь объеокттой, 1519 нэгж талбар нь хоосон байгаа судалгаа гаргасан. Газар эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдэд олгосон зөрчлийг арилгахаар 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 болон Ойн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн цахим сайтаар газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай албан мэдэгдэл хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2022 оны А/422 дугаар захирамжаар 86 иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг хүчингүй болгосон.	100
29	Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөлийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг баталгаажуулах, газар ашиглалтын зориулалт, талбайн хэмжээ, байршилд өөрчлөлт оруулах, эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, хугацааг сунгах, газар эзэмших,	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн шинээр газар эзэмших, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх, газар эзэмших эрхийн хугацаа сунгуулах, талбай, зориулалт, байршил өөрчлөх тухай 14897 хүсэлт ирснээс дүүргийн газар зохион байгуулалтын албаны дэргэдэх “Газрын эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөлийн хурал”-д танилцуулан хянуулж, дүүргийн Засаг даргын 214 удаагийн захирамжаар 11418 иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг шийдвэрлэсэн.	100

	ашиглах эрхийг хүчингүй болгох асуудлуудыг тухай бүрд нь хэлэлцэж шийдвэрлэх		
30	Газрын нэгдсэн мэдээллийн сан дахь кадастрын зургийн мэдээллийг хянан шалгаж, бодит газраасаа зөрүүтэй бүртгэгдсэн нэгж талбаруудын судалгааг боловсруулж, зөрчил арилгах ажлыг зохион байгуулах.	Газрын кадастрын мэдээллийн санг зохих журмын дагуу хөтөлж, газрын удирдлагын системээс 7975 иргэн, хуулийн этгээдэд газрын мэдээллийн сангийн кадастрын зурган мэдээллээр үйлчилж байна. Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг 2018 оноос ашиглаж эхэлсэнтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг үнэн зөв бүртгэн оруулах, нөхөн бүрдүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд иргэдийн газар өмчлөлийн гэрчилгээг газрын кадастрын мэдээллийн санд тулгалт хийн мэдээллийн санд зөрчилтэй, бүртгэлд ороогүй 12834 иргэний мэдээллийг засварлан оруулаад байна.	100
1.6 Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил			
31	Дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.	Баянзүрх дүүргийн Засаг даргын 2021 оны А/415 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий Климакс реферэнс ХХК-иар дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд буй 221 ширхэг геодезийн байнгын цэг тэмдэгт байгаа бөгөөд 170 ширхэг геодезийн байнгын цэг тэмдэгт устаж 51 цэг тэмдэгт бүрэн байгаа судалгаа гарсан. Дээрх устсан цэг тэмдэгтийг сэргээх шаардлагатай санхүү төсвийг суулгуулахаар дүүргийн Засаг даргад 10 дугаар сарын 31-ны өдрийн 15/1793 тоот албан бичгээр хүргүүлсэн. Баянзүрх дүүргийн газар зохион байгуулалтын 2 дугаар албаны хариуцах нутаг дэвсгэрт фото мониторингийн 2 цэг байдаг. 33 дугаар хорооны нутаг давсгэр, Баяндөхөм Гүнжийн ам, 35 дугаар хорооны нутаг дэвсгэр Улиастайн голд юм. 8 дугаар сарын 10-ны өдрөөс 15-ны өдрийг хүртэлх хугацаанд фото мониторингийн хээрийн хэмжилт, зураглалын ажлыг бүрэн хийж дуусгасан ба Sample Point программд боловсруулалтыг хийж гүйцэтгэсэн. Мөн мэдээллийг газрын удирдлагын системд 100 хувь бүрэн оруулсан.	100

32	Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим систем, гар утасны аппликейшнд хөгжүүлэлт хийж газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хувь хүн, хуулийн этгээдүүд өөрийн газартай холбоотой төрийн үйлчилгээг газрын удирдлагын цахим системийг ашиглаж хүсэлт гаргах, хамааралтай мэдээ мэдээллийг зохих журмын дагуу түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх.	Нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын хэмжээнд хийгдэж байгаа ажил, мэдээ, мэдээллийг албаны цахим хуудсандаа тогтмол байршуулан ажиллаж байна. Газартай холбоотой ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг 132125 тусгай дугаараар мессэж бичиж хариу хүргэх үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна. Уг үйлчилгээ нэвтэрсэн өдрөөс хойш нийт **22384** иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хариу мэдээг мессэжээр хүргэсэн байна. Энэ онд 10923 иргэн, аж ахуйн нэгжид холбогдох хариу мэдээг мессэжээр хүргэсэн байна. Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны цахим үйлчилгээг хороодоос үзүүлэх тухай” А/84 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах, цахим систем Egazar.gov.mn-ийг сурталчлах, газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх, хорооны Засаг дарга болон хэсгийн ахлагч нартай хамтран төлөвлөгөөнд тусгагдсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг авах, 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгах өмчлөлтэй холбоотой саналыг хороодоос хүлээн авах ажлаар Баянзүрх дүүргийн 35 хороодод сургалт арга зүйгээр ханган ажиллалаа.	100
1.7 Газрын татвар, төлбөр, үнэлгээний чиглэлээр хийх ажлууд			
33	Нийслэлийн төсвийг бүрдүүлэхэд газрын төлбөрөөс оруулах орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллаж, шинээр тогтоосон үнэлгээний бүсчлэлийн дагуу шаардагдах гэрээнүүдийг шинэчлэх, шинээр байгуулсан гэрээг бүртгэн тайланд тусгах, дүгнэх болон нийтийн эзэмшлийн газарт байрлан үйл ажиллагаа явуулж байгаа газруудаас төлбөр авах, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг тухай бүр дүгнэн дутуу төлөлт, хүү, торгууль, алданги тооцох зэргээр төлбөрийн баазыг нэмэгдүүлж ажиллах.	2022 онд дүүргийн Засаг даргын захирамжтай 29972 гэрээнд 2,591,236,487 төгрөгийн ногдуулалт хийж, 28902 гэрээнд 2,528,539,339 төгрөгийн нэхэмжлэл үүсгэсэн. “Цахим хөгжил-Иргэдийн оролцоо” жилийн аяны хүрээнд газрын төлбөрийг цахимаар төлөх боломжийг иргэд олон нийтэд таниулах ажил, үйлчилгээ хийсэн. Үүнд тараах нийт 500 материал, гарын авлага хэвлүүлэн олон нийт ихээр цуглардаг зах, худалдааны төвүүдэд байршуулах, 2 удаагийн бичлэг шторк хийж олон нийтэд хүргэх, албаны цахим хуудсанд төлбөр төлөх хялбар аргуудыг сурталчилан таниулах, мөн нэхэмжлэл авах, төлбөрөө төлөх иргэн, хуулийн этгээдэд тухай бүр зөвлөгөө, сурталчилгаа өгч ажиллах зэрэг ажил үйлчилгээг тухай бүр хүртээмжтэй хийж гүйцэтгэлээ. Газрын төлбөрийн үлдэгдэлтэй нийт 967 иргэн, хуулийн этгээдийн судалгааг гарган 7 удаагийн масс мессеж хүргүүлж, Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй хамтран 1 сарын хугацаатай газрын төлбөр төлөлтийг эрчимжүүлэх удирдамж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Баянзүрх дүүргийн татварын хэлтэстэй хамтран “Газрын төлбөрийн 2022 оны төсөв бүрдүүлэх аян”-ны хүрээнд: • Газрын төлбөрийн үлдэгдэлтэй 538 иргэн, хуулийн этгээдийн судалгааг нэгтгэн гаргаж газар дээр нь очиж ажилласан. • Газар эзэмшиж, ашиглаж байгаа хуулийн этгээдийн санхүү хариуцсан ажилтан, алба хаагчдад 3 удаагийн сургалт зохион байгуулсан. • Нийтийн эзэмшлийн зам, талбайд үйл ажиллагаа явуулж буй 200 гаруй түр байгууламж /өргөтгөл /-ийн суурин судалгааг боловсруулж, .shp файлтай холбохоор хээрийн судалгаа хийж, газрын төлбөр төлөх мэдэгдэл өгсөн. • Газрын төлбөр, татвар, egazar аппликейшн, egazar.gov.mn цахим хуудасыг сурталчилсан 1 шторк бэлдэж, цахим орчинд түгээсэн. • Газрын төлбөрийн үлдэгдэлтэй иргэн, хуулийн этгээдэд үүрэн холбооны операторуудаар 6 удаагийн давтамжаар 3906 иргэнд масс мессэж илгээсэн.	31.5

		• Хөрөнгийн бүртгэл үүсээгүй 4166 гэрээг газрын төлбөр, татварын системд илгээж, бүртгэв. Тайлант хугацаанд Газрын кадастрын мэдээллийн системд суурилсан Газрын төлбөр, татварын системд Газрын татвар, төлбөрийг газрын төлбөрөөс төвлөрүүлэх 19,000,000,000 төгрөгийн төлөвлөгөөтэй ба Үүнээс 2022 онд газрын төлбөр, татварын системээр үүсгэгдсэн 22,044 нэхэмжлэхээс 5,953,633,907 төгрөг, Төрийн сан 100200300943 тоот дансаар төлөгдсөн 36,562,537 төгрөг нийт 5,990,196,444 төгрөг төлөгдсөн буюу **31,5 %-**ийн биелэлттэй байна.	
34	Нийслэлийн газрын үнэлгээг бодитой болгох зорилгоор зах зээлийн үнийн мэдээллийг дүүрэг тус бүрээр нэгтгэн цуглуулах, бүртгэл, мэдээллийн сан бий болгох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийн санг Газрын биржийн цахим систем, Газрын кадастрын мэдээллийн санд суурилан цуглуулах ажлыг зохион байгуулах, олон нийтэд ил тод болгох ажлын хүрээнд Газрын биржийн цахим системийн мэдээллийн бааз бэлтгэх зорилгоор зах зээлийн үнийн мэдээллийг 2022 онд **MLE.MN** системд 457 газар эзэмшигч, ашиглагч нарын мэдээллийг бүртгэн оруулав.	100
35	Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ноогдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах	Газрын кадастрын мэдээллийн системд суурилсан Газрын төлбөр, татварын системд Газрын татвар, төлбөрийг газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер программ хангамжийг ашиглан бүрэн ногдуулж, тайлагнах ажлын хүрээнд Газрын төлбөр, татварын системд 2022 онд ногдуулалт үүссэн хүчинтэй гэрээний тоо нийт 29,995 байна. Үүнээс нэхэмжлэх үүссэн гэрээний тоо 28,925 буюу 96.4 %-ийн биелэлттэй байна.	96.4
1.8 Газрын маргаан, зөрчил арилгах, газар чөлөөлөх талаар			
36	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, авто болон явган хүний зам хааж байрлуулсан объектууд, эзэмшил, ашиглалтад байгаа газраа дур мэдэн нэмж ашигласан хашаа, хайс, байгууламж, объект зэргийг нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөх чиг үүрэг бүхий “Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээ”-г зохион байгуулах	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор Орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчил болох Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Автай сайн хотхоны" урд байрлах олон жил болсон барилгын цамхагт краныг нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1011 дүгээр захирамжийн дагуу албадан буулгаж, газар чөлөөлсөн. Тус дүүргийн нутаг дэвсгэрт орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн орц, гарц хаасан нийт 75 байршилд газрын зөрчлийн судалгааг гаргасан. Дүүргийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгаж орц, гарц, чөлөөлөх тухай” А/149 дүгээр захирамжийг үндэслэн нийт 23 байршлаас 23 байршлын зөрчлийг арилгасан. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/585 дугаар захирамжийн хүрээнд нутаг дэвсгэрт нийт 52 байршилд газар чөлөөлөлт хийхээр төлөвлөснөөс 49 байршилд газар чөлөөлөлтийн ажлыг хийж гүйцэтгэж, зөрчлийг арилгасан.	94.7
37	Улс, нийслэл, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжаар хийгдэх улсын болон орон нутгийн чанартай авто зам, инженерийн шугам сүлжээний трасст орсон иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрыг нөхөх олговортойгоор чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.	Дүүргийн 27 дугаар хороо Дунд Дарь Эхийн 17 дугаар гудамж, 132 дугаар сургуулиас төв зам хүртэлх 1,1 км үргэлжлэх шинээр барих авто замын ажлын хүрээнд: Тус замын ажлын нөлөөлөлд нийт 54 нэгж талбар өртсөнөөс эдэлбэр газраа хэтрүүлэн барьсан 15 хашаа өртсөн. Тус 15 иргэнд хашаагаа татах хугацаатай мэдэгдэл өгч 14 айлын хашааг татуулж, 1 айлын зөвшөөрөлгүй байшинг чөлөөлөхөөр зөвшилцөлд хүрээд байна. Мөн 39 иргэнд нөхөн олговортой газар чөлөөлөхөөр байгаа бөгөөд нөхөн олговрын үнэлгээ хийгдсэн. Дүүргийн 8-23 хороо Гачууртын авто замаас Шар хадны эцсийн зогсоол хүртлэх 4,27 км авто замын ажлын хүрээнд:	100

		Авто замын нөлөөлөлд 114 нэгж талбарын 14005 м.кв газар өртсөн. 66 нэгж талбар нөлөөлөөс гарсан, 26 нэгж талбар захирамж гарсан, 6 нэгж талбар зөвшөөрөөгүй, 5 нэгж талбар захирамжийн төсөлд, 11 нэгж талбар зөвшилцөх ажил хийгдэж байна. Дүүргийн 24 дүгээр хороонд “ИЕОН ГЭГЭЭ” ХХК-ий гүйцэтгэж буй Цахлайн 2 дугаар гудамжнаас Цахлайн 6 дугаар гудамж хүртэлх 0.647 км авто замын ажлын хүрээнд: Замын трассын нөлөөлөлд 8 нэгж талбар өртсөнөөс 6 нэгж талбар өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайгаас сунгаж хашаа барьсан байсныг “Газрын тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4 дэх хэсгүүдийг үндэслэн хугацаатай мэдэгдэл өгч хашааг татуулж, 2 нэгж талбарыг нөхөн олговортойгоор чөлөөлж, замын ажил саадгүй хэрэгжих нөхцөл боломжоор ханган ажилласан. Дүүргийн 21 дүгээр хороо, Бага Дарь Эхийн гудамж, 850 метр авто замын ажлын хүрээнд: Газар чөлөөлөлтийн ажил 100 хувьтай, зам барилгын ажил хийгдэж дууссан. Дүүргийн 27 дугаар хороо, Жамсран Уулын Ар гудамж, 1,0 км авто замын ажил. Газар чөлөөлөлтийн ажил 100 хувьтай, замын ажил хийгдэж дууссан. Дүүргийн 2 дугаар хороо, КТМСургууль, Дарь Эхийн гудамж 1,8 км авто замын ажлын хүрээнд: Замын ажил эхлээгүй ба авто замын нөлөөлөлд өртсөн 2 иргэнтэй зөвшилцөлд хүрээгүй, газар чөлөөлөлтийн ажил 97 хувьтай. Дүүргийн 24 дүгээр хороонд “Шинэ цагийн зам” ХХК-ий гүйцэтгэж буй, Цахлайн 2 дугаар гудамжнаас Хоршооллын 6 дугаар гудамж хүртэлх 0.52 км авто зам. Замын трассын нөлөөлөлд 18 нэгж талбар өртсөнөөс 17-н нэгж талбар нь өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайгаас сунгаж хашаа барьсан байсныг “Газрын тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4 дэх хэсгүүдийг үндэслэн хугацаатай мэдэгдэл өгч хашааг татуулсан. Трассын нөлөөлөлд өртсөн 1 иргэний газар болон эд хөрөнгөд үнэлгээ хийлгэн, газрыг нөхөн олговортойгоор чөлөөлж, замын ажил саадгүй хэрэгжих нөхцөл боломжоор хангасан. Дүүргийн 24 дүгээр хороонд “Таны зам” ХХК-ий гүйцэтгэж буй Жаргалантын 3 дугаар гудамжнаас Жаргалантын 4 дүгээр гудамж хүртэлх 0.62 км авто замын трассын нөлөөлөлд 16 нэгж талбар өртсөнөөс 15-н нэгж талбар нь өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайгаас сунгаж хашаа барьсан байсныг “Газрын тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4 дэх хэсгүүдийг үндэслэн хугацаатай мэдэгдэл өгч зөрчлийг арилгасан. Трассын нөлөөлөлд өртсөн 1 иргэний газар болон эд хөрөнгөд үнэлгээ хийлгэн, газрыг нөхөн олговортойгоор чөлөөлж, замын ажил саадгүй хэрэгжих нөхцөл боломжоор хангасан. Дүүргийн 24 дүгээр хороо Жаргалант, Овоот, Хоршооллын, хэсэгт “Үйлсийн зам” ХХК-ий гүйцэтгэж буй 0.6 км авто замын трассын нөлөөлөлд 27 нэгж талбар өртсөнөөс 25-н нэгж талбар нь өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайгаас сунгаж хашаа барьсан байсныг “Газрын тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4 дэх хэсгүүдийг үндэслэн хугацаатай мэдэгдэл өгч хашааг татуулсан. Трассын нөлөөлөлд өртсөн 2 иргэний газар болон эд хөрөнгөд үнэлгээ хийлгэн чөлөөлж, замын ажил саадгүй хэрэгжих нөхцөл боломжоор ханган ажиллалаа. Дүүргийн 28 дугаар хороонд “Таны зам” ХХК-ий гүйцэтгэж буй Улиастай шинэ эцсийн уулзвараас Хужирбулан хүртэлх 1. 5 км авто замын трассын нөлөөлөлд 17 нэгж талбар өртсөнөөс 10-н нэгж талбар нь өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайгаас сунгаж хашаа барьсан байсныг “Газрын тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4 дэх	

		хэсгүүдийг үндэслэн хугацаатай мэдэгдэл өгч зөрчлийг арилгасан. Трассын нөлөөлөлд өртсөн 7 иргэний газар болон эд хөрөнгөд үнэлгээ хийлгэн, газрыг нөхөн олговортойгоор чөлөөлж, замын ажил саадгүй хэрэгжих нөхцөл боломжоор хангасан.	
38	Улс нийслэлийн төсөвт хөрөнгө тусгагдсан сургууль, цэцэрлэгийн барилгын газарт орсон, мөн орон нутгийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт хийх зэрэг байршилд иргэн, хуулийн этгээдийн газар чөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэх.	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт шинээр тавигдах авто замын трассын нөлөөлөлд 259 нэгж талбар өртсөнөөс 157-н нэгж талбар нь өөрийн эзэмшил, өмчлөлийн талбайгаас сунгаж хашаа барьсан байсныг “Газрын тухай хууль”-ийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4 дэх хэсгүүдийг үндэслэн хугацаатай мэдэгдэл өгч хашааг татуулсан. Трассын нөлөөлөлд өртсөн 86 иргэний газар болон эд хөрөнгөд үнэлгээ хийлгэн, газрыг нөхөн олговортойгоор чөлөөлж, замын ажил саадгүй хэрэгжих нөхцөл боломжоор хангасан. Тухай авто замуудын трассын нөлөөлөлд өрсөн 25 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 700 м2 газрын тус тус олгосон.	100
39	Гэр хорооллын гудамж талбайд зөвшөөрөлгүй хашаа барих, сунгах орц гарцыг хаасан, багасгасан зэрэг зөрчил гаргасан газруудыг хууль тогтоомжийн дагуу шаардах хуудас, мэдэгдэл өгч чөлөөлөх ажлыг зохион байгуулж, зөрчлийг тухай бүр арилгаж “Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээ”-нд хамруулж ажиллах.	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр, гэр хорооллын гудамж талбайд зөвшөөрөлгүй хашаа барих, сунгах орц гарцыг хаасан, багасгасан зэрэг зөрчил гаргасан газруудыг хууль тогтоомжийн дагуу 70 иргэн хуулийн этгээд судалгаа гаргаж шаардах хуудас, мэдэгдэл хүргүүлж, 2023 оны “Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээ”-нд хамруулан ажилласан.	100

ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээг тогтоох							
Д/Д	**Хороо**	**Газрын байршил**	**Зориулалт**	**Газрын хэмжээ** (га)	**Иргэдийн тоо**	**Хэрэгжилт**	**Хувь**
1	**2**	**3**	**4**	**5**	**6**	**7**	**8**
1.	2	Их Дарь-эх	Гэр бүлийн хэрэгцээ	0.75	12	9	75.0
2.	4	Цэргийн хотхон гудамж		1.15	30	7	23.3
3.	5	Монелийн гудамж		2.45	68	24	35.3
4.	8	Улаанхуаран, Эрдэнэтолгой, Холбоо толгойн гудамж		0.5	9	7	77.7
5.	9	Ээж хайрхан, Цагаан даваany ам, Шар хад, Тоосгоны ар, Үнэгтийн ам, Давсны булаг		13.1	231	135	58.4
6.	10	Витсамо, Улаанхуаран, Амгалан, Төмөр зам, Хангамжийн гудамж		2.2	50	3	6.0
7.	11	Товчоо, Туул, Эмийн ургамал, Хонхор, Усан сан, Сүүл даваа, Нам даваа, Хонхор нуур, Дэнж, Баянбулаг, Баянзүрх, Ургах наран, Булгачин, Хөлийн гол		69.86	1155	533	46.2
8.	12	Сармисны хонхор, Жанжин, Чулуут, Төмөр зам		1.36	27	1	3.7
9.	13	Дүүрэг		0.06	2	0	0.0
10.	14	Консул		0	0	0	0.0
11.	16	72 хотхон		0.07	2	2	100.0
12.	17	Ногоочин, Эрдэнэтолгой, Эмнэлэг		0.55	21	4	19.1
13.	19	Цайз, Жаргалант, Дэнж		1.55	28	13	46.4
14.	20	Булагийн ам, Баяндөхөм, Улиастай ам, Гүнжийн хоолой, Шар хоолой, Их ам, Бага ам, Туул ферм, Шивэртийн ам, Сүүл даваа Дархитын ам, Хуандайн ам, Арцатын ам, Дээндийн ам, Могойт дэнж, Хар усан тохой Майхан уулын зүүн энгэр		741.27	11860	4642	39.1
15.	21	Бага Дарь-Эх, Сэлбэ, Жамсран уулын Өвөр болон Ар, Ганц худгийн ам, Богдын даваа,Тоосгоны үйлдвэрийн орчим		4.7	94	2	2.1
16.		Ганцын худгийн задгай (Хорих ангийн хамгаалалтын бүсэд орсон айл)		43.0	850	86	10.1

17.	22	Баруун алтан өлгий, Зүүн алтан өлгий, Бунханы		2.7	60	14	23.3
18.	23	Улиастайн хэсэг, Баатархайрханы хэсэг, Сургуулийн хэсэг		26.78	447	247	55.3
19.	24	Цахлай, Овоот Жаргалант, Хоршооллын гудамж, Газарчин		4.3	87	43	49.4
20.	27	Дунд дарь-эх, Сэлбэ		2.4	40	31	77.5
21.	28	Хужирбулан 1, 2, 3, 4, 5 дугаар хэсэг		5.3	83	45	54.2
Нийт				**924.05**	15156	5848	38.6

2.2. Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ						
